

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2010 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2010.02.21

Улаанбаатар хот

**НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ**

2010 онд нийт 20 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 15 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 182 ББСБ-ын санхүүгийн тайлан нэгтгэлд хамрагдсан бөгөөд 2006 оны жилийн эцсийн тайлант хугацаанаас хойш ББСБ-уудын тоонд дараах өөрчлөлт орсон байна.


/Хүснэгт 1/

№	Тайлант хугацаа	Тусгай зөвшөөрөл олгосон	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо
1	2006 он	2	24	139
2	2007 он	10	12	137
3	2008 он	10	15	132
4	2009 он	56	11	177
5	2010 он	20	15	182

Хорооны хуралдааны шийдвэрээр 2010 онд 81 ББСБ-ын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 17 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх арга хэмжээ авч, 5 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлснийг сэргээсэн байна.

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоог өмнөх онуудтай харьцуулвал:

/График 1/



2010 оны жилийн тайлант хугацаан дахь ББСБ-уудын тайлангийн нэгтгэлийн голлох статистик үзүүлэлтүүдийг харуулбал:

/Хүснэгт 2/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2010 оны IV улирал	2009 оны IV улирал	Өөрчлөлт
1	ББСБ-ын тоо	182	177	5
2	Хувь нийлүүлэгчдийн тоо	582	497	85
3	Ажиллагсадын тоо	880	746	134
4	Салбар нэгжийн тоо	63	58	5
5	Харилцагчдын тоо	158,510.0	108,293	50,217.0
6	Нийт актив /мян.төг/	128,606,250.3	96,480,115.70	32,126,134.6
	Банкны салбарт эзлэх хувь	2.1%	2.2%	-0.1%

7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	78,085,816.6	49,954,945.9	28,130,870.7
Банкны салбарт эзлэх хувь		2.4%	2.0%	0.4%
8	Нийт эзэмшигчдийн өмч /мян.төг/	91,961,546.2	68,888,094.1	23,073,452.1
Банкны салбарт эзлэх хувь		24.0%	32.5%	-8.5%
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мян.төг/	80,014,795.6	61,421,490.8	18,593,304.8
Банкны салбарт эзлэх хувь		33.0%	25.9%	0.07
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мян.төг/	6,211,906.1	3,225,052.3	2,986,853.8
11	Нийт орлого /мян.төг/	30,102,545.6	19,596,686.5	10,505,859.1
12	Нийт зардал /мян.төг/	22,970,109.4	15,844,583.4	7,125,526.0
13	Тайлант үеийн ашиг /мян.төг/	7,132,436.2	3,752,103.1	3,380,333.1
I	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ- ын тоо	15	8	7
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь		8.2%	4.5%	3.7%
A	Нийт актив /мян.төг/	23,566,259.36	12,694,871.0	10,871,388.4
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		18.3%	13.2%	5.2%
B	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	17,393,222.17	9,250,929.8	8,142,292.4
ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь		22.3%	18.5%	3.8%
B	Нийт эзэмшигчдийн өмч /мян.төг/	10,819,241.86	6,337,361.8	4,481,880
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		11.8%	9.2%	2.6%
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мян.төг/	10,797,666.97	6,721,032.5	4,076,634.5
ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь		13.5%	10.9%	2.6%
II	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	26	26	0
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь		14.3%	14.7%	-0.4%
A	Нийт актив /мян.төг/	4,230,401.80	3,018,985.4	1,211,416
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		3.3%	3.1%	0.2%
B	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	5,292,775.10	2,260,602.5	3,032,172.6
ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь		6.8%	4.5%	2.3%
B	Нийт эзэмшигчдийн өмч /мян.төг/	4,013,977.77	2,713,231.2	1,300,746.6
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		4.4%	3.9%	0.4%
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мян.төг/	3,752,952.22	2,393,459.20	1,359,493.0
ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь		4.7%	3.9%	0.8%
III	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	48	47	1
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь		26.4%	25.8%	0.5%
A	Нийт актив /мян.төг/	6,308,654.12	5,724,465.1	584,189.0
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		4.9%	5.9%	-1.0%
B	Нийт эзэмшигчдийн өмч /мян.төг/	5,886,669.47	5,699,789.3	186,880.2
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх		6.4%	8.3%	-1.9%

хувь				
В	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мян.төг/	5,115,993.37	5,046,367.1	69,626.3
ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь		6.4%	8.2%	-1.8%

Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:

2010 оны жилийн эцсийн байдлаар гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 15 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 8.2 хувийг, тэдгээрийн нийт актив ББСБ-ын нийт активын 18.3 хувийг, нийт олгосон зээл нь нийт ББСБ-уудын олгосон зээлийн 22.3 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчийн өмчийн 11.8 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 13.5 хувийг тус тус эзэлж байна. Тэдгээрийг гадаадын хөрөнгө оруулагчдын харьяаллаар нь авч үзвэл, Дэлхийн Зөн Олон улсын байгууллагаас санхүүжигдсэн 1, Япон улсын хөрөнгө оруулалттай 7, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 4, Итали улсын хөрөнгө оруулалттай 1, АНУ-ын хөрөнгө оруулалттай 1, ОХУ-ын хөрөнгө оруулалттай 1 ББСБ тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:

2010 оны 4 дүгээр улирлын байдлаар орон нутагт төвтэй 26 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 14.3 хувийг, тэдгээрийн нийт актив нь нийт ББСБ-ын активын 3.3 хувийг, нийт олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив нь нийт ББСБ-ын 6.8 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 4.4 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 4.7 хувийг тус тус эзэлж байна.

/График 2/



Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дангаар эрхлэн явуулж буй ББСБ:

2010 оны 4 дүгээр улирлын байдлаар гадаад валютын арилжааг дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 45 ББСБ, зээл, гадаад валютын арилжаа эрхлэх зөвшөөрөлтэй 3 ББСБ буюу нийт 48 ББСБ зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 26.4 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 4.9 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 6.4 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 6.4 хувийг тус тус эзэлж байна.

ББСБ-уудыг Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээг эрхэлж буйгаар нь ангилвал:

/Хүснэгт 3/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо
---	---------------------------	--------------------------------------

		2010 оны IV улирал	2009 оны IV улирал
1	Зээл	134	132
2	Факторингийн үйлчилгээ	8	6
3	Төлбөрийн баталгаа гаргах	6	5
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	0
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	5	5
6	Гадаад валютын арилжаа	96	105
7	Итгэлцлийн үйлчилгээ	10	11
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	1	2
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	9	7
10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	0	0
11	Хөрөнгө оруулалтын үйлчилгээ ¹ /Венчур хөрөнгө оруулалт/	1	1

Тайлант хугацаанд Хорооноос нэр бүхий нийт 20 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх арга хэмжээ авсан байна.

Мөн 2010 оны тайлант хугацааны эцэст эхлэлтийн тайлан тэнцлийн дүнгээр 4 ББСБ нэгтгэлд хамрагдсан бол 20 ББСБ өмнөх тайлант үеүдийн дүнгээр тайлангийн нэгтгэлд хамрагдсан.

ХОЁР. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Активын бүтэц, өөрчлөлт:

ББСБ-уудын 2010 оны жилийн тайлант хугацааны нийт активын бүтцийг өмнөх онтой харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна.

/Хүснэгт 4/

№	ХӨРӨНГӨ	2010.12.31		2009.12.31		Өөрчлөлт	
		дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь
A	Эргэлтийн хөрөнгө	123,376,635.2	95.9	92,326,922.2	95.7	31,049,713.0	33.6
1	Мөнгөн хөрөнгө	38,234,867.6	29.7	31,019,402.0	32.2	7,215,465.6	23.3
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	1,766,523.8	1.4	1,948,117.6	2.0	-181,593.8	-9.3
3	Нийт зээл	78,085,816.6	60.7	55,504,753.9	57.5	22,581,062.7	40.7
	(Зээлийн эрсдлийн сан)	3,687,308.5	2.9	3,257,571.3	3.4	429,737.2	13.2
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	1,904,127.3	1.5	1,079,999.6	1.1	824,127.8	76.3
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	0.0	0.0	497.7	0.0	-497.7	-100.0
5	Нийт факторингийн тооцооны авлага	123,448.2	0.1	350.0	0.0	123,098.2	35170.9

¹ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны хуульд заагдсан тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамаарахгүй бөгөөд Хорооны 2009 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 185 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэх түр журам"-ыг үндэслэн Эн Ви Си ББСБ-д уг үйлчилгээг эрхлэх зөвшөөрлийг олгосон.

	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	0.0	0.0	350.0	0.0	-350.0	-100.0
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	689,437.0	0.5	401,677.0	0.4	287,759.9	71.6
7	Бусад хөрөнгө	6,259,723.2	4.9	5,631,041.1	5.8	628,682.2	11.2
Б	Эргэлтийн бус хөрөнгө	5,229,615.1	4.1	4,153,193.5	4.3	1,076,421.6	25.9
8	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	5,229,615.1	4.1	4,153,193.5	4.3	1,076,421.6	25.9
	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	6,820,027.1	5.3	5,525,277.3	5.7	1,294,749.7	23.4
	(Хуримтлагдсан элэгдэл)	1,590,412.0	1.2	1,372,083.9	1.4	218,328.1	15.9
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		128,606,250.3	100.0	96,480,115.7	100.0	32,126,134.6	33.3

2010 оны жилийн тайлант хугацаанд нийт актив өмнөх оны мөн үеэс 33.3 хувиар өссөн ба ийнхүү өсөхөд ББСБ-уудын үйл ажиллагааны үр дүн болох хуримтлагдсан ашгийн 54.1, нийт өр төлбөрийн 69.3 хувийн болон хувьцаат капитал /дүрмийн сан/-ын 20.6 хувийн өсөлтүүд тус тус голлох нөлөөг үзүүлсэн байна.

Тайлант хугацаан дахь зээлийн үлдэгдэл нь нийт активын 60.7 хувь, мөнгөн хөрөнгө 29.7 хувийг буюу нийт 90.4 хувийг эзэлж байгаа нь ББСБ-уудын үндсэн эрхэлж буй үйл ажиллагаа нь зээлийн үйл ажиллагаа байгаа болохыг илтгэж байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалтын 94,9 хувь нь нэг ББСБ-ын тайлан тэнцэлд бүртгэгдсэн бөгөөд энэ нь тус ББСБ-д Хорооны 2008 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 185 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэх түр журам”-ыг үндэслэн олгосон зөвшөөрлийн дагуу хийгдсэн 1,640,524.8 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт болон тус ББСБ-ын хувь нийлүүлэгчдийн шийдвэрийг үндэслэн гаргасан өрийн бичгийн 72,604.0 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

Санхүүгийн түрээсийн тооцооны авлага, факторингийн тооцооны авлагууд нь тус тус 100.0 хувь нэг нэг ББСБ-д бүртгэлтэй байна.

2.2 Зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 5/

№	Ангилал	2010.12.31		2009.12.31		Өөрчлөлт	
		дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь
1	Хэвийн зээл	70,700,950.6	90.5	47,399,071.6	85.4	23,301,879.0	49.2
2	Хугацаа хэтэрсэн зээл	2,647,890.2	3.4	3,192,871.6	5.8	-544,981.4	-17.1
3	Чанаргүй зээл. Үүнээс:	4,736,975.8	6.1	4,912,810.7	8.9	-175,834.9	-3.6
	а/ Хэвийн бус	916,945.3	1.2	1,384,491.1	2.5	-467,545.9	-33.8
	б/ Эргэлзээтэй	924,077.2	1.2	1,403,245.3	2.5	-479,168.1	-34.1
	в/ Муу	2,895,953.3	3.7	2,125,074.2	3.8	770,879.1	36.3
НИЙТ		78,085,816.6	100.0	55,504,753.9	100.0	22,581,062.7	40.7

2010 оны жилийн тайлант хугацааны зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, нийт зээлийн багц 40.7 хувиар өссөнөөс зээлийн багцад эзлэх хувийн жингээр хэвийн зээл 5.1 хувиар өссөн бол, чанаргүй зээл 2.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2.3. Активын үзүүлэлтүүдийн харьцуулсан судалгаа:

ББСБ-уудын системийн нийт зээлийн багцын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна.

/График 3/



Графикаас харахад өнгөрсөн 10 жилийн хугацааны туршид зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 2007 онд хамгийн өндөр үзүүлэлттэй байсан ба 2009 онд өмнөх оноос 3.2 хувиар өссөн нь санхүү, эдийн засгийн хямралтай холбоотойгоор зээлдэгчдийн үйл ажиллагааны орлого буурсан, барьцааны эд зүйлийг худалдан борлуулах замаар зээлийг эргэн төлүүлэх хууль эрх зүйн орчин төдийлэн таатай бус байсан, зарим ББСБ-уудын удирдлагын хувьд зохих менежментийг хангаж ажиллаж чадахгүй байгаатай холбоотой байсан гэж үзэх бүрэн үндэслэлтэй байх ба 2010 онд өмнөх оноос 2.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ББСБ-уудын системийн нийт активын голлох үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 4/



/График 5/



/График 6/



ГУРАВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

ББСБ-уудын 2010 оны жилийн тайлант хугацааны нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх онтой харьцуулж үзвэл дараах байдалтай байна.

/Хүснэгт 6/

№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2010.12.31		2009.12.31		Өөрчлөлт	
		дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь
A	Өр төлбөр	30,427,530.3	23.7	17,847,461.9	18.5%	12,580,068.4	70.5
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	6,211,906.1	4.8	3,653,513.1	3.8	2,558,392.9	70.0
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	19,585,495.7	15.2	10,689,685.1	11.1	8,895,810.6	83.2
3	Бусад эх үүсвэр	435,232.5	0.3	757,561.5	0.8	-322,329.0	-42.5
	Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	0.0	0.0	1,059.3	0.0	-1,059.3	-100.0
	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	428,526.2	0.3	665,873.5	0.7	-237,347.4	-35.6

	Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	3,007.0	0.0	0.0	0.0	3,007.0	-
	Факторингийн үйлчилгээний өглөг	0.0	0.0	0.0	0.0	0.0	-
	Гадаад валютын арилжааны эх үүсвэр	3,699.4	0.0	90,628.7	0.1	-86,929.3	-95.9
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	400,000.0	0.3	0.0	0.0	400,000.0	-
5	Төслийн зээлийн санхүүжилт	3,794,896.1	3.0	2,746,702.2	2.8	1,048,193.9	38.2
	Бусад өр төлбөр	6,217,173.8	4.8	3,792,151.7	3.%	2,425,022.0	63.9
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	1,058,993.5	0.8	284,060.5	0.3	774,933.0	272.8
7	Бусад пассив	5,158,180.2	4.0	3,508,091.2	3.6	1,650,089.0	47.0
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	0.0	0.0	0.0	0.0	0.0	-
	Нийт өр төлбөр	36,644,704.1	28.5	21,639,613.6	22.4	15,005,090.5	69.3
Б	Эзэмшигчдийн өмч	91,961,546.2	71.5	74,840,502.0	77.6	17,121,044.2	22.9
9	Хувьцаат капитал	80,014,795.6	62.2	66,367,214.5	68.8	13,647,581.1	20.6
10	Бусад өмч	519,908.4	0.4	496,841.8	0.5	23,066.6	4.6
11	Сангууд	1,122,224.7	0.9	1,100,073.0	1.1	22,151.7	2.0
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	9,381,384.2	7.3	6,088,662.8	6.3	3,292,721.4	54.1
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	923,233.4	0.7	787,710.0	0.8	135,523.4	17.2
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ	128,606,250.3	100.0	96,480,115.7	100.0	32,126,134.6	33.3

Тайлант хугацаанд өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 69.3 хувиар, эзэмшигчдийн өмч 22.9 хувиар тус тус өссөн бөгөөд 2009 оны тайлант хугацаанд нийт эх үүсвэрийн 24.4 хувийг нийт өр төлбөр, 77.6 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2010 оны тайлант хугацааны нийт эх үүсвэрт эзлэх нийт өр төлбөр 28.5 хувь, эзэмшигчийн өмч 71.5 хувь болж өөрчлөгдсөн байна. Нийт эх үүсвэрт эзлэх нийт өр төлбөр өссөн гол шалтгаан нь нэг талаас ББСБ-уудын хувьцаат капитал болон хуримтлагдсан ашиг өссөн, нөгөөтэйгүүр, ББСБ-уудын итгэлцлийн үйлчилгээний өглөг, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хэмжээ өссөнтэй холбоотой.

Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй 10 ББСБ байгаагаас 2010 оны жилийн эцсийн тайлант хугацаанд тэдгээрийн нийт итгэлцлийн өглөгийн хэмжээ 6,211,906.1 мянган төгрөг байна.

Харин цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 5 ББСБ байгаагаас 2010 оны жилийн эцсийн тайлант хугацаанд 4 ББСБ-ын нийт мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг 428,526.2 мянган төгрөг байна.

Мөн 2010 оны жилийн эцсийн тайлант хугацаанд 6 ББСБ нийт 923,233.4 мянган төгрөгийн 2-догч өглөгтэй байна.

Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэр өмнөх оноос өссөн, өөрийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдсэн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн тогтвортой байдлын хувьд эерэг үзүүлэлт болж байна.

Өөрийн хөрөнгийн өсөлтөд Хорооны 2008 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн “Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 169

дүгээр тогтоолоор үүрэг болгосны дагуу ББСБ-ууд дүрмийн сангаа нэмэгдүүлсэн нь голлох үүрэг гүйцэтгэсэн.

ББСБ-уудын системийн нийт активын голлох үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.


/График 7/




/График 8/



/График 9/



/График 10/

**ДӨРӨВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА**

2010 оны жилийн тайлант хугацааны нийт орлого өмнөх оны мөн үеэс 12.8 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

/Хүснэгт 7/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.12.31		2009.12.31		Өөрчлөлт	
		дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь
1	ХҮҮГИЙН ОРЛОГО	20,676,621.2	68.7	15,239,694.6	57.1	5,436,926.7	35.7
	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	19,018,221.9	63.2	14,570,271.1	54.6	4,447,950.7	30.5
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	1,065,450.5	3.5	315,156.7	1.2	750,293.8	238.1
	Үнэт цаасны хүүгийн орлого	61,156.0	0.2	24,551.5	0.1	36,604.5	149.1
	Бусад хүүгийн орлого	531,792.9	1.8	329,715.2	1.2	202,077.7	61.3
2	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	8,416,589.6	28.0	11,132,600.8	41.7	-2,716,011.2	-24.4
3	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	986,638.7	3.3	292,516.4	1.1	694,122.3	237.3
4	ЕРДИЙН БУС ОРЛОГО	22,696.1	0.1	15,863.3	0.1	6,832.7	43.1
	НИЙТ ОРЛОГО	30,102,545.6	100.0	26,680,675.1	100.0	3,421,870.5	12.8

2009 оны тайлант хугацааны нийт орлого өмнөх оноос 12.8 хувиар өссөн нь ББСБ-уудын эзэмшигчдийн өмчийн өсөлт, бусдаас татсан эх үүсвэрийн өсөлттэй шууд холбоотой бөгөөд нийт орлогын өсөлтөд үндсэн үйл ажиллагааны орлого болох хүүгийн болон хүүгийн бус орлогын өсөлт нөлөөлсөн байна.

Харин хүүгийн бус орлого өмнөх оны мөн үеэс 24.4 хувиар буурсан байх ба тайлант хугацааны нийт орлогын 68.7 хувийг хүүгийн орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн орлогын дүнтэй харьцуулахад 11.6 хувиар өссөн/, 28.0 хувийг хүүгийн бус орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн бус орлогын дүнтэй харьцуулахад 13.7 хувиар буурсан/ эзэлж байна.

/Хүснэгт 8/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.12.31		2009.12.31		Өөрчлөлт	
		дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь
1	Арилжааны орлого	2,594,686.2	30.8	5,694,847.8	51.2	-3,100,161.6	-54.4

1.1	Гадаад валютын арилжааны орлого	2,594,686.2	30.8	5,694,847.8	51.2	-3,100,161.6	-54.4
1.2	Үнэт цаасны арилжааны орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2	Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	4,061,764.1	48.3	4,351,664.8	39.1	-289,900.7	-6.7
2.1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	4,061,764.1	48.3	4,323,601.6	38.8	-261,837.5	-6.1
2.2	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	0.0	0.0	28,063.2	0.3	-28,063.2	0.0
3	Санхүүгийн үйлчилгээний орлого	1,760,139.3	20.9	1,086,088.2	9.8	674,051.0	62.1
3.1	Санхүүгийн түрээсийн орлого	351.0	0.0	3,715.2	0.0	-3,364.1	-90.6
3.2	Итгэлцлийн үйлчилгээний орлого	1,115.9	0.0	217.3	0.0	898.6	413.5
3.3	Мөнгөн гуйвуулгын орлого	645,627.5	7.7	427,626.5	3.8	218,001.0	51.0
3.4	Картын үйлчилгээний орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.5	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	68,358.7	0.8	64,969.6	0.6	3,389.1	5.2
3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	739,640.7	8.8	433,633.5	3.9	306,007.2	70.6
3.7	Бусад	305,045.4	3.6	155,926.1	1.4	149,119.3	95.6
	НИЙТ ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	8,416,589.6	100.0	11,132,600.8	100.0	-2,716,011.2	-24.4

2009 оны тайлант хугацааны эцэст нийт хүүгийн бус орлогын 51.1 хувийг гадаад валютын арилжааны орлого, 39.1 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 9.8 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байсан бол 2010 оны тайлант хугацааны эцэст нийт хүүгийн бус орлогын 30.8 хувийг гадаад валютын арилжааны орлого, 48.3 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 20.9 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого тус тус эзэлсэн байна.

Харин дээрх тайлант онуудын нийт зардлын бүтэц дараах байдалтай байна.

/Хүснэгт 9/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.12.31		2009.12.31		Өөрчлөлт	
		дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь
1	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	2,394,449.9	10.4	2,458,124.1	11.3	-63,674.2	-2.6
2	ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	16,984,728.2	73.9	16,510,765.2	76.1	473,963.0	2.9
3	БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ	2,247,029.4	9.8	1,799,739.6	8.3	447,289.8	24.9
4	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	387,168.8	1.7	288,038.2	1.3	99,130.6	34.4
5	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	12,632.8	0.1	12,403.3	0.1	229.5	1.9
6	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	944,100.4	4.1	625,577.0	2.9	318,523.4	50.9
	НИЙТ ЗАРДАЛ	22,970,109.4	100.0	21,694,647.4	100.0	1,275,462.0	5.9

2009 оны жилийн тайлант хугацааны нийт зардал өмнөх оны мөн үеэс 5.9 хувь /2009 онд өмнөх оноос 45.0 хувиар өсч байсан/-аар өссөнөөс хүүгийн зардал 2.6 хувиар буурсан, хүүгийн бус зардал 2.9 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 24.9 хувиар, үндсэн бус үйл

ажиллагааны зардал 34.4 хувиар, орлогын татварын зардал 50.9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Өөрөөр хэлбэл, 2010 оны тайлант хугацаанд нийт орлого 12.8 хувиар өссөн бол нийт зардал 5.9 хувиар өссөн байна.

Активын болзошгүй эрсдэлийн зардлын өсөлт нь ББСБ-уудын зээлийн багцын чанар муудаж, чанаргүй зээлийн хэмжээ байнга өсөн нэмэгдсээр байгааг илтгэж байна.

ББСБ-ууд нь 2009 оны жилийн тайлант хугацаанд нийт 7,132,436.2 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 43.0 хувийн өсөлттэй /2009 оны жилийн тайлант хугацааны цэвэр ашиг 4,986,027.7 мянган төгрөг/ байх ба, энэ үзүүлэлтийг тухайн тайлант үеүдийн нийт орлогод эзлэх хувиар тооцвол 5.0 хувиар өссөн /2010 онд 23.7 хувь, 2009 онд 18.7 хувь, 2008 онд 20.8/ үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл, өмнөх онтой харьцуулахад системийн хувьд нийт ашиг нэмэгдсэн нь ББСБ-уудын активын өсөлт, ББСБ-ын тооны өсөлтөөс гадна тэдгээрийн үйл ажиллагааны үр ашиг нэмэгдсэн нэмэгдсэнтэй шууд хамааралтай болохыг харуулж байна.

2010 онд давхардсан тоогоор 119 ББСБ нийт 114,210.9 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хороонд төвлөрүүлсэн байна.


ББСБ-уудын системийн орлого, зарлага, ашгийн үзүүлэлтийг өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна.

/График 11/



Харин сүүлийн 11 жилийн хугацаанд ББСБ-ын салбарын татварын дараах цэвэр ашгийн нийт орлогод эзлэх хувь хэмжээ дараах байдалтай байна.

/График 12/



ТАВ. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ББСБ-ын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2008 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

- нийт өөрийн хөрөнгө 91,961,546.2 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 89,134,816.1 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хувьд 101.6 хувь, өөрийн хөрөнгийн хувьд 103.2 хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд 70.5 хувь;

- түргэн борлогдох актив 39,928,839.4 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 22,330,414.8 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 178.8 хувь;

- валютын дансны цэвэр зөрүү 5,799,346.1 мянган төгрөг, валютаарх өөрийн хөрөнгө 91,961,546.2 мянган төгрөг байгаагаас гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 6.31 хувь;

- итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 6,211,906.1 мянган төгрөг, хувьцаат капитал 80,014,795.6 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын харьцаа 7.8 хувь;

- нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 2,213,066.2 мянган төгрөг, нийт актив 128,606,250.3 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.7 хувь байгаа нь зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.

Харин активын эрсдэлийн санг 4,104,903.1 мянган төгрөгөөр байгуулбал зохихоос 96,392.4 мянган төгрөгөөр илүү буюу нийт 4,201,295.49 мянган төгрөгөөр байгуулсан байна.²

ЗУРГАА. БҮЛГИЙН САНХҮҮГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хорооны 2008 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх журам”-ын дагуу ББСБ-ын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээрх шалгалтын дүнгээр санхүүгийн тайлан тэнцэлд үндэслэн холбогдох үзүүлэлтүүдийг тооцож бодитой үнэлгээ, дүгнэлт өгөхтэй холбогдуулан 2010 оны 1 дүгээр улирлаас эхлэн нийт ББСБ-уудыг активын хэмжээгээр нь 1,000,000.0 мянган төгрөг ба түүнээс дээш төгрөгийн активтай, 400,000.0 мянган төгрөгөөс 1,000,000.0 мянган төгрөг хүртэл активтай, 400,000.0 мянган төгрөг хүртэл активтай болон зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлдэг ББСБ гэсэн 4 бүлэгт хуваан бүлэг тус бүрийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тооцож ирсэн.

ББСБ бүрийн активын өөрчлөлтөөс хамаарч эдгээр бүлгүүдийн бүтэц нь улирал тутамд шинэчлэгдэж байдаг бөгөөд 2010 оны 4 дүгээр улирлын байдлаарх бүлгүүдийн ерөнхий бүтэц дараах байдалтай байна:

/Хүснэгт 10/

№	Бүлэг	Бүлэгт хамаарах ББСБ-ын тоо	Бүлгийн нийт актив		Нэмэлт мэдээлэл
			Актив /мян.төг/	Нийт активт эзлэх хэмжээ /хувь/	
1	Бүлэг 01	28	79,231,089.2	61.6	1,000,000.0 мянган төгрөгөөс дээш хэмжээний активтай
2	Бүлэг 02	68	35,419,478.1	27.5	400,000.0 мянган төгрөгөөс 1,000,000.0 мянган төгрөг хүртэл хэмжээний активтай
3	Бүлэг 03	38	7,647,028.8	5.9	400,000.0 мянган төгрөг хүртэл хэмжээний активтай

² Энэхүү тоон үзүүлэлтийг гаргахдаа тухайн ББСБ-уудын ТОП20 зээлдэгчийн мэдээлэлд тулгуурлан гаргасан болно.

4	Бүлэг 04	48	6,308,654.1	5.0	Зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлдэг бөгөөд 44,210.5 мянган төгрөгөөс 1,098,006.0 мянган төгрөгийн активтай
НИЙТ		182	128,606,250.3	100.0	

2010 оны 4 дүгээр улирлын байдлаарх бүлгүүдийн тайлант үеийн татварын дараах цэвэр ашиг, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

а/ Тайлант үеийн татварын дараах цэвэр ашиг:

/Хүснэгт 11/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Ашиг	Салбарын нийт татварын дараах цэвэр ашигт эзлэх хэмжээ /хувь/
1	Бүлэг 01	5,956,930.7	83.5
2	Бүлэг 02	1,346,031.0	18.9
3	Бүлэг 03	-251,884.2	-3.5
4	Бүлэг 04	81,358.7	1.1
НИЙТ		7,132,436.2	100.0

б/ Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт:

/Хүснэгт 12/

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Бүлэг 01 /хувь/	Бүлэг 02 /хувь/	Бүлэг 03 /хувь/	Бүлэг 04 /хувь/
1	<i>Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтүүд</i>				
А	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн активын харьцаа (10 хувиас багагүй байх)	75.6 хангасан	134.3 хангасан	150.7 хангасан	1,269.1 хангасан
Б	Өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн активын харьцаа (20 хувиас багагүй байх)	77.3 хангасан	136.1 хангасан	153.9 хангасан	1,361.7 хангасан
В	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа (10 хувиас багагүй байх)	58.4 хангасан	89.8 хангасан	92.9 хангасан	87.0 хангасан
2	<i>Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт</i>				
А	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа (8 хувиас доошгүй байна)	93.0 хангасан	879.7 хангасан	1,418.5 хангасан	109,051.4 хангасан
3	<i>Активын эрсдлийн сангийн хүрэлцээний үзүүлэлт</i>				
А	Активын эрсдлийн сангийн хүрэлцээ (+ илүү, - дутуу) /мянган төгрөгөөр/	77,153.2 мянган төгрөгөөр илүү байгуулсан	58,058.5 мянган төгрөгөөр дутуу байгуулсан	77,297.7 мянган төгрөгөөр илүү байгуулсан	зөв байгуулсан
4	<i>Гадаад валютын эрсдлийн үзүүлэлт</i>				
А	Нэгж валютын хувьд (+/- 40 хувь)	4.6 хангасан	6.5 хангасан	7.6 хангасан	17.1 хангасан
Б	Нийт валютын хувьд (+/- 40 хувь)	4.6 хангасан	6.5 хангасан	7.6 хангасан	17.1 хангасан
5	<i>Итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын үзүүлэлт</i>				

А	Итгэлцлийн үйлчилгээний өглөгийн дүн хувьцаат капиталын (80 хувиас хэтрэхгүй)	16.1 хангасан	тооцох шаардлагагүй	тооцох шаардлагагүй	тооцох шаардлагагүй
6	<i>Үндсэн хөрөнгийн үзүүлэлт</i>				
А	Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн дүн нийт активын (15 хувиас хэтрэхгүй)	1.6 хангасан	1.5 хангасан	4.4 хангасан	0.3 хангасан

Бүлгүүдийн актив, ашгийн үзүүлэлтүүдийг харахад “Бүлэг 01”-д хамаарах 28 ББСБ /нийт ББСБ-ын 13.7 хувь/ нь бүхий л үзүүлэлтүүдээр голлох байр суурийг эзэлж байна.

Харин Хорооны 2009 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор зарим тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 28 дугаар тогтоол батлагдсанаар валют солих цэгийн үйл ажиллагаа эрхэлж байсан, цаашид эрхлэх хүсэлтэй аливаа этгээд нь банк бус санхүүгийн гадаад валютын арилжааг Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх эрх зүйн үндэс бүрэлдсэнээс хойш уг үйл ажиллагааг эрхлэхээр хүсэлтээ Хороонд ирүүлсээр байгаа бөгөөд тайлант хугацаанд уг үйл ажиллагааг дангаар эрхэлж буй нэр бүхий ББСБ-ууд /2010 оны 4 дүгээр улирлын байдлаар 48 ББСБ буюу нийт ББСБ-ын 26.4 хувь/ нь 2010 оны 2 дугаар улирлын байдлаар 35,111.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилаж байсан бол, 3 дугаар улирлын байдлаар 124,180.2 мянган төгрөгийн, 4 дүгээр улиралд 81,358.7 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

ДОЛОО. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛБЭЛ ЗОХИХ АРГА ХЭМЖЭЭ

Хороо санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийнхээ дагуу дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна. Үүнд:

1. ББСБ-уудаас хүлээн авах санхүүгийн тайлан мэдээ, мэдээллийг цуглуулах мэдээллийн сан, нэгдсэн сүлжээтэй болох арга хэмжээний хэрэгжилтийг түргэвчлэх;
2. ББСБ-уудын дийлэнх хэсэг нь зээл, гадаад валютын үйл ажиллагаа эрхэлж байгаа, энэ утгаараа банк бус санхүүгийн үйл ажиллагааг бүрэн цогцоор нь төдийлэн эрхлэхгүй байгаатай холбогдуулан аль болох хуульд заасан санхүүгийн бусад үйл ажиллагааг эрхлэх боломжийг нээх тал дээр дэмжиж ажиллах;
3. ББСБ-тай холбоотой санхүүгийн нэгдэл, бусад холбогдох этгээдийн үйл ажиллагаанд нэгдсэн хяналт, шалгалт хийх ажлын хүрээнд Монголбанк болон төрийн холбогдох бусад байгууллагуудтай хамтран ажиллах;
4. ББСБ-уудын үйл ажиллагаанд хийх газар дээрх болон хяналт, шалгалт болон мониторингийн чанар, үр нөлөөг илүү чанаржуулах;
5. Хөдөө орон нутаг дахь ББСБ-уудын үйл ажиллагаанд гүйцэтгэх газар дээрх хяналт, шалгалтын ажлыг идэвхижүүлэх;
6. Хугацаандаа болон улирал дараалан Хороонд ирүүлбэл зохих санхүүгийн тайлан, бусад тайлан, мэдээг ирүүлдэггүй ББСБ-уудад тооцвол зохих хариуцлагын арга хэмжээг өндөржүүлэх;
7. Зохицуулалтын байгууллага, тэдгээрийн удирдлага, ажилтнуудад зориулсан хууль тогтоомж, заавар журмыг таниулах ажлын хүрээнд сургалтын болон бусад зохион байгуулалтын арга хэмжээг нэмэгдүүлэх.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР